



Хөрөнгө
Оруулагч Үйлдвэрлэл

ХҮЧТЭЙ. ХАМТДАА.

ARD

Investor Nation

Stronger. Together.

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

2015 ЖИЛИЙН ТАЙЛАН

ARD

Investor Nation

Stronger. Together.

FOX

ARD



Агуулга

1. Мэндчилгээ	04	24	11. Санхүүгийн гүйцэтгэл
2. Түүх	07	26	12. Хөрөнгө оруулалтын бүтэц
3. Эрхэм Зорилго, Алсын Хараа	08	27	13. Хөрөнгө оруулалтын түүх, өгөөж
4. Мөрдөх зарчим	09	28	14. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
5. Давуу шинж чанар	10	29	15. Хувьцааны арилжааны мэдээлэл
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд	12	30	16. Цаашдын зорилго, төлөвлөгөө
7. Монгол Улсын эдийн засгийн байдал, үзүүдэлт	14	31	17. Тайлангийн хугацааны удаах үйл явдал
8. Монгол Улсын санхүүгийн салбар, үзүүлэлт	16	32	18. Хөрөнгө оруулалттай компаниудын тайлан
9. 2015 оны үйл явдлын товчоон	18	48	19. Аудитлагдсан тайлан
10. Гүйцэтгэлийн тайлан	20	54	20. Нэгтгэсэн аудитлагдсан тайлан

Мэндчилгээ

Сайн байна уу. Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхэндээ Ард Санхүүгийн Нэгдэл (цаашид Ард Холдингс гэх) хаалттай хувьцаат компанийн 2015 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг дэлгэн танилцуулж байгаадаа бид туйлын баяртай байна. Бидний та бүхэнд хүргэж байгаа тайланд дурьдсан бүхий л ажил, амжилт нь Ард Холдингсын хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ гэх) болон гүйцэтгэх удирдлагын баг, ажилчдын хамтын хүчин зүтгэлийн үр дүн билээ. Монгол орны нийгэм улстөрийн нөхцөл байдал сайнгүй байгаа энэ үед хийж гүйцэтгэсэн ажил, гаргасан амжилт, алдаа оноогоо илэн далангүй хүүрнэсэн тайлангаа та бүхэнд хүндэтгэлтэйгээр хүргүүлж байгааг хүлээн авч болгооно уу?.

Манай хувьцаа эзэмшигчид ээлжит хурлаа хийж хэд, хэдэн чухал шийдвэрийг гаргаж өгсөнд бид талархаж байца. Хувьцаа эзэмшигчдээс олгогдсон эрхийн дагуу ТУЗ ч мөн олон чухал шийдвэрийг цаг алдалгүй гаргаж, зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал аван аль болох цаг алдалгүй бүтээлчээр ажиллахыг эрмэлзэж ирсэн болно. Бидний нөхцөл байдлыг ойлгож, ямагт дэмжиж ирсэн та бүхэндээ талархал илэрхийлье.

Ард Холдингсын томоохон хувьцаа эзэмшигч болсон Голландын VenturesOne компанийг

төлөөлж Их Британийн иргэн Энтони Хоброу 2015 оны эхнээс манай ТУЗ-д ажиллах болсон бол Швейцарийн Adveq компанийн үүсгэн байгуулагч Бруно Рашле 8 дугаар сараас бидний урилгыг хүлээн авч нэгдэн орлоо. ТУЗ өнгөрсөн жил 4 удаа нэгдсэн хурал хийсэн бөгөөд цаг үеийн асуудал, гүйцэтгэх удирдлагын тайланг авч хэлэлцэхээс гадна сайн засаглалын тогтолцоог төлөвшүүлэх чиглэлээр чамгүй ахиц гаргаж чадлаа. Манай ТУЗ-ийн дэргэд Эрсдлийн Удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын Хороо, Аудитын Хороо, Засаглал, Цалин Урамшууллын Хороо байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрлээ.

Бид ТэнГэр Санхүүгийн Нэгдэлд эзэмших 4.26 хувиа худалдах, нэр бүхий хувьцаа эзэмшигчдээс хувьцааг нь эргүүлэн худалдан авах шийдвэрийг гаргаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд Жинст Увс ХК-ийн 84.6 хувийг Монголын Хөрөнгийн Бирж дээрээс блок арилжаагаар худалдан авч, компанийн хуулийн статусыг өөрчлөн хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах дүрмээ баталлаа.

2015 оны сүүл дээр Монгол Шуудан ХК-ийн 34 хувийг хувьчлах ажиллагааг Засгийн Газраас зарлаж 20 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн нь бидний хувьд яаралтай байдлаар, хамаг хүчээ дайчлан ажиллахыг шаардсан онцгой нөхцөл байдлыг үүсгэсэн болно. Гүйцэтгэх удирдлага

болон ТУЗ хамгийн бүтээлч, харилцан итгэлцэл дээр тулгуурлан зүтгэсний үр дүнд энэхүү хувьчлалд Ард Холдингс амжилттай оролцон Монгол Шуудангийн 17.38 хувийг нийт 3.3 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь Ард Холдингсын хувьцаа эзэмшигчдийн хувьд эерэг бөгөөд том үйл явдал болсон гэж бид дүгнэж байна.

Бидний хамтын ажиллагааны үр дүнд манай нэгж хувьцааны үнэлгээ 2,024 төгрөгнөөс 2,176 төгрөг болж өслөө. Бид нээлттэй хувьцаат компани болох бүхий л бэлтгэл ажлыг базааж байна. ТУЗ өөрийн үндсэн үүрэг болох гүйцэтгэх удирдлагад чиглэл өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавин удирдлагын багийг бүхий л талаар дэмжиж ажиллалаа. Бид гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хязгаарыг тогтоож, ажиллагсадын хувьцаа эзэмших хөтөлбөрийг хэлэлцэн батлаж, стратегийн бизнес төлөвлөгөөгөө боловсруулан 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвөө баталлаа.

Манай хувь нийлүүлэгчид хувьцаагаа хоорондоо өгөлцөж, авалцах үйл ажиллагаа ч идэвхтэй өрнөж, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд том өөрчлөлт орсоор байна. Он дамжин байж амжилттай явагдсан UBIG, Apollo Ventures-ын хэлцэл үүнд хамгийн их нөлөө үзүүлсэн бол Ард Секюритизын тусламжтайгаар бид зарим хувьцаа эзэмшигчдийн хувьцааг шинэ жижиг хөрөнгө оруулагчдад амжилттай зуучилж өгснөөр манай хувьцаа эзэмшигчдийн тоо

өнгөрсөн 10 гаруй жилийн буурах хандлагаа өөрчилж, 12 дугаар сараас эхлэн өсч, он гарахад 600-д хүрлээ.

Сүүлийн хэдэн жил ярьж, төлөвлөсөн Ард Менежментийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтын болон хувийн хэлбэрийн хөрөнгө оруулалтын санг байгуулж ажиллахад бид бэлэн болсон бөгөөд 2016 он гарсаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсоноор өнөөгийн хямралтай байгаа зах зээлд бидэнд дахин нэгэн боломжийн үүд хаалга нээгдлээ.


Бид 2016 онд олон нийтээс хөрөнгө, санхүүжилт босгож, санхүүгийн салбарт цогц үйл ажиллагаатай олон түмний өмчийн нэгдэл болох зорилгоо хэрэгжүүлэхэд бэлэн болов.

Үүний сацуу Ард Кредит, Ард Даатгалыг тус бүрийн салбартаа анхлан нээлттэй хувьцаат компани болгох ажлыг бид анхааралтай судалж байгаа бөгөөд ойрын хугацаанд шийдэл гаргахаар ажиллаж байна.

Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнд нэгдсэн мянга мянган жирийн иргэд, хөрөнгө оруулагчдын итгэлийг дааж ажиллах шаардлага үүсч байгааг бид ухамсарлаж байгаа.

Бидэнд итгэл найдвар хүлээлгэн хөрөнгө оруулж, хувьцаа эзэмшигч болсон явдалд танд ТУЗ болон удирдлагын багийн нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Бид та бүхний итгэлийг алдалгүй, Компанийн үнэ цэнийг хамгаалж, хувьцааны үнэ цэнийг өсгөх ажилдаа шамдан ажиллах болно.

ТУЗ-йн Дарга Ж.Оюунгэрэл
Гүйцэтгэх Захирал Ч.Ганхуяг



Түүх

Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Корпс төрийн бус байгууллагаас ХасБанкны ажиллагсад болон байгууллага, түүний хувь нийлүүлэгчдийн урт хугацааны ашиг сонирхлыг нийцүүлэх, бизнес санхүүгийн салбарт оруулж буй хувь нэмрийг нь үнэлэн ХасБанкны нийт ажиллагсдад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгодоо нэгдэн өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-GE ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-GE ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд банк, даатгал, лизингийн үйлчилгээ үзүүлдэг томоохон санхүүгийн компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Манай компани нь 2005 оны 9 дүгээр сард ХасБанкны үүсгэн байгуулагч гүйцэтгэх удирдлагын санаачлагаар "Employee Investment Trust" буюу ИАЙТи ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд ажиллагсад болон удирдлага банкныхаа бодлогод нэгдмэл байр суурьнаас оролцох үүднээс банкны нийт ажиллагсдын хувьцааг татан төвлөрүүлж, Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

ИАЙТи нь 2005 онд үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн өмч бүхий дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар 600 орчим хувьцаа эзэмшигчтэй, 35.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна. Анхны хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг олон зуу дахин өсгөж чадсан амжилтаар бид энэхүү шинэ үеийн хуудсыг нээж байна.

2013 онд манай гол хувь нийлүүлэгчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, энэхүү стратегийнхаа хүрээнд арилжааны банк, брокер дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын сан, даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээг иж бүрнээр нь үзүүлэх компаниудын нэгтгэл болж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм.

Шинээр тогтоосон алсын харааныхаа хүрээнд бид 2013 онд Ард Кредит, Ард Даатгал компаниудад эхний хөрөнгө оруулалтыг хийж, Ард Активыг шинээр эмхлэн байгуулж, Ардын хөгжлийн түншлэлийг бий болгож ажиллаж ирлээ.

Монгол хүн бүтээсэн баялгийнхаа эзэн суух ёстой гэдэг итгэл үнэмшилдээ хөтлөгдөн ажилласан сүүлийн жилүүдийн ажлын үр дүн гарч Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2015 оны сүүлээр хэлбэрээ өөрчлөн хаалттай хувьцаат компани болж бүртгүүлж чадлаа.




Эрхэм зорилго

Ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэржүүлэн барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд түвшинд барих бодлогыг мөрдөнө.

Алсын хараа

Бид хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг дээдэлсэн Үндэсний хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани мөн.

Мөрдөх зарчим



Давуу шинж чанар



ТУЗ-ийн гишүүд

Баяртогтох НЭМЭХБААТАР
(Заг ХХК)
-
Засаглал, Цалин урамшууллын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 540,834

Чулуун ГАНХУЯГ
(Ард Санхүүгийн Нэгдэл ХК)
-
Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 1,290,000

БРУНО Рашле
(Adveq)
-
Засаглал, Цалин урамшууллын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 461,016

Галбадрах ЦОГБАДРАХ
(Хараат бус)
-
Аудитын хороо; Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 73,390

Жанчив ОЮУНГЭРЭЛ
(Луна Энд Луна ХХК)
-
Засаглал, Цалин урамшууллын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 1,373,801

Нямтайшир ЦЭЛМҮҮН
(МАК ХХК)
-
Аудитын хороо; Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 873,000


Пүрэвжаргал БАТБАЯР
(Хараат бус)
-
Засаглал, Цалин урамшууллын хороо; Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 9,000

Одончимэд ОДБАЯР
(Мон Интернэйшнл ХХК)
-
Аудитын хороо; Засаглал, Цалин урамшууллын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 452,000

Лхагвасүрэн СОРОНЗОНБОЛД
(Хараат бус)
-
Аудитын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 405,210

ЭНТОНИ Хоброу
(VenturesOne)
-
Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 1,304,043

Ванданцэрэн БАЯРЖАРГАЛ
(Интергрупп Интернэйшнл)
-
Эрсдлийн удирдлага, Санхүү, Хөрөнгө Оруулалтын хороо
-
Хувьцааны тоо ширхэг: 1,871,276



Эдийн Засаг

Эдийн засаг 2015 онд 2.3 хувиар өсч, өсөлтийн хурд өмнөх оноос огцом буураад байна. 2014 онд 19.4 хувийн өсөлттэй байсан уул уурхайн салбар 2015 онд 13 хувь өссөн нь энэхүү бууралтад голлон нөлөөлсөн байна. Мөн бусад салбаруудын өсөлт өмнөх оноос буурсан байна.


Тухайлбал, хөдөө аж ахуй цаг уурын нөхцөл байдлаас үүдэн өмнөх оны өсөлтөөс 3 нэгжээр бага өссөн бол тээвэр агуулахын салбар 9.1 нэгж, үйлчилгээний салбар 7.3 нэгжээр тус, тус буурсан байна. Харин барилгын салбар 2014 он 4.3 хувиар унаж байсан бол 2015 онд 1.4 хувь болж, уналтын хурд саарсан байна.

2015 онд төлбөрийн тэнцэл 268 сая долларын алдагдалтай гарч, гадаад валютын нөөц уг дүнгээр буурч 1,323.1 сая доллар болсон байна. Хэдийгээр төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсан ч өмнөх жилийн алдагдлаас энэ нь 43 хувиар буурсан бөгөөд энэ нь урсгал тэнцлийн алдагдал буурсантай холбоотой байна. 2014 онд урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 11.9 хувьтай тэнцэж байсан бол 2015 онд 4.9 хувь болж буурсан байна. Аж ахуйн нэгж байгууллагуудын гаднаас авсан зээлийн санхүүжилт буурсантай холбогдуулан гадаадын шууд хөрөнгө оруулалт тайлант хугацаанд 183 сая доллар болж, өмнө оноос 93 сая доллараар буурсан байна.

Гадаад худалдааны эргэлт өмнөх онтой харьцуулахад 23.1 хувиар буурч, 8,466.6 сая долларт хүрсэн байна. Экспорт болон импорт 2014 онтой харьцуулахад 19.1 болон 27.5 хувиар буурсан нь энэхүү бууралтад нөлөөлжээ. Экспортын бууралттай харьцуулахад импорт хурдтай буурсан нь гадаад худалдааны тэнцлийг эерэг буюу 872.3 сая долларын ашигтай гарахад нөлөөлсөн байна.


2014 оны 3 дугаар улирлаас хэрэглээний үнийн индексийн өсөлтийн хурд тогтвортой буурч байгаа бөгөөд 2015 оны байдлаар 1.9 хувьд хүрсэн. Энэхүү өсөлтөд боловсролын үйлчилгээ 23.1 хувь, хувцасны бүлгийн үнэ 5.5 хувь, орон сууцны бүлгийн үнэ 3.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний сагсыг бүрдүүлдэг хүнсний барааны бүлэг 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2014 оны 2 дугаар хагасаас Монголбанк бодлогын хүүгээ 2 удаа нэмэгдүүлж, 2015 онд 13 хувьд хүргэсэн, мөн M2 мөнгөний нийлүүлэлт 2015 оны байдлаар өмнөх жилтэй харьцуулахад 5.5 хувиар буурсан нь мөнгөний бодлогын төлөв хатуурах чиглэлд шилжиж байгааг харуулж байна. Пассив талаасаа M2 мөнгөний нийлүүлэлтийн бууралтын 0.2 нэгжийг төгрөгийн хадгаламжийн өсөлт, 0.2 нэгжийг гадаад валютын хадгаламж, 1.2 нэгжийг M1 мөнгө буюу төгрөгийн харилцах болон банкнаас гадуурх мөнгө, 4.3 нэгжийг гадаад валютын харилцахын бууралтаар тус тус тайлбарлаж байна.




Эдийн Засгийн зарим үзүүлэлт


ДНБ-ийн өсөлт (салбар, улирал)




Гадаад худалдаа




Төлбөрийн тэнцэл (сая доллар)




Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр, сая доллар)



M2 мөнгөний өсөлт (пассив талын задаргаа)




Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт



Санхүүгийн салбар

2001 оноос хойш 13 жил өсөлттэй байсан зээлийн өрийн үлдэгдэл 2015 онд 11,695.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноосоо 6.5 хувиар буурав. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь тайлант хугацаанд 7.1 хувьд хүрч 2014 оноос өсөв. Чанаргүй зээлийн харьцаа уул уурхайн салбарт 24.4 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 12.0 хувьтай байгаа нь бусад салбартай харьцуулахад хамгийн өндөр гарлаа.

Зээл (тэрбум төгрөг)




2015 онд 450 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад ББСБ-ын нийт актив 22.7 хувиар өсч, 623.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны нийт активын 3 хувьтай тэнцсэн байна. Тус салбарын зээлийн өрийн үлдэгдэл 391 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 29.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа 9.8 хувь болж, өмнөх оноос 3.5 нэгжээр нэмэгдсэн байна.

Үнэт цаасны компанийн тоо 2012 онд хамгийн их буюу 80 хүрч байсан бол сүүлийн 3 жилд тасралтгүй буурч тайлант онд 58-д хүрлээ. Энэ нь үндсэн үйл ажиллагаа болох хувьцааны арилжаа буурсантай холбоотой болно. 2015 онд 546.4 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 8 дахин өссөн үзүүлэлт бөгөөд үүнд Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан арилжаалж эхэлсэн нь нөлөөллөө. Нийт арилжааны 94.4 хувийг ЗГҮЦ-ны арилжаа эзэлж байна. 2015 онд нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1,262.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 12.5 хувиар буурсан.


Даатгалын салбарт 2015 онд ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын салбарын нийт актив 173.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 13.6 хувиар өссөн байна. Нийт хураамжийн орлого өсч, 113.9 тэрбум хүрсэн. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 13.1 хувиар буюу орлогын өсөлттэй харьцуулахад хурдтай өсч, 36.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Санхүүгийн салбарын зарим үзүүлэлт


ББСБ-ын тоо, нийт актив (тэрбум төгрөг)




Зээл (тэрбум төгрөг)




Үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөг)




Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)



Даатгалын компанийн тоо, нийт актив (тэрбум төгрөг)



Даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлт (тэрбум төгрөг)



2015 оны үйл явдлын товчоон



- **1 дүгээр сарын 14** ТУЗ-ийн ээлжит хурал болов.
- **1 дүгээр сарын 27** Охин компани "Монет Капитал" нэрээ "Ард Секюритиз" ҮЦК болгон өөрчилснийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлав.
- **1 дүгээр сарын 31** Ард Холдингс Төв аймгийн Батсүмбэр суманд ажиллаж, "Хас Баяжих" хоршооны хуралд танилцуулга хийв.
- **1 дүгээр сар** Монголын пара пауэрлифтингийн тамирчин Э.Содномпилжээг БНСУ-ын Инчеон хотод зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь дэмжиж ажиллав.
- **2 дугаар сар** Ард Холдингс Өнгөт хэвлэлийн байранд нүүж оров.
- **3 дугаар сарын 23** Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг Жинст Увс ХК-ийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц болох 84.6 хувь буюу 45,028 ширхэг хувьцааг блок арилжаагаар худалдан авлаа.
- **2 дугаар сарын 27** МУСТА, жүжигчин Р.Анхнямын тоглосон "Чонон Сүлд" уран сайхны киног Монголд гаргах эрхийг авахад тусалж, Монгол дахь нээлтийг нь ивээн тэтгэв.
- **4 дүгээр сарын 2-3** Монголын Эдийн Засгийн Форумын 6 дахь удаагийн чуулганд ивээн тэтгэгчээр оролцлоо.
- **5 дугаар сарын 1** Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал боллоо.

- **5 дугаар сар** Улаанбаатар хотын Худалдааны танхимыг үүсгэн байгуулалцаж, Удирдах Зөвлөлийн гишүүнээр Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг сонгогдов.
- **5 дугаар сар** Porsche World Roadshow in Mongolia арга хэмжээг Ард Даатгал ХХК-тай хамтран дэмжив.
- **5 дугаар сар** Ардынхан "Дуулиан 2015" сонирхогчдын хөлбөмбөгийн тэмцээнд оролцов.
- **6 дугаар сар** Швейцарь улсын Adveq сангийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга Бруно Рашле хувьцаа эзэмшигч болов.
- **6 дугаар сарын 10** Ардын ажилчид "Найрсаг Улаанбаатар" нийтийн марафон гүйлтэнд хамт олноороо оролцлоо.
- **6 дугаар сар** Нийслэлийн 29 дүгээр дунд сургуулийн сурагчдад хүүхдийн баярын бэлэг гардуулав.
- **7 дугаар сар** Монголын Бизнесийн Зөвлөлийн "BSM 2015" хөлбөмбөгийн тэмцээнийг ивээн тэтгэв.
- **7 дугаар сарын 9** "Шөнийн Музей" хөтөлбөрийн хүрээнд Чойжин Ламын Сүм музейд зохион байгуулагдсан "Хөсөгтөн" хамтлагийн тоглолтыг ивээн тэтгэж, Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран ажиллав.
- **8 дугаар сарын 2** Монголд анх удаа зохион байгуулагдсан Эндюрокроссын Улсын Аварга Шалгаруулах тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр оролцлоо.

- **8 дугаар сарын 18** ОУХМ О.Жавзмааг 2015 оны Жудо бөхийн ДАШТ-нд оролцоход нь дэмжиж ажиллав.
- **8 дугаар сарын 31** Хувьцаа эзэмшигч Бруно Рашле Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдлоо.
- **9 дүгээр сарын 2-5** Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг Япон улсад зохион байгуулагдсан "G1 Summit" хуралд панелистаар оролцов.
- **10 дугаар сарын 2-5** Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой хамтран Баруун бүсийн чуулга уулзалтыг Баян-Өлгий аймагт зохион байгуулав.
- **10 дугаар сарын 10** Ард Холдингсын бүх ажилчид "1000 төгрөг" сайн үйлсийн аянд нэгдлээ.
- **10 дугаар сарын 23** Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг "Орос-Монголын хамтарсан 3 дугаар дунд сургууль"-ийн сурагчдад "Даян Дэлхийн Нэр Төрөө Эрхэмлэх Өдөр"-н хүрээнд уулзалт, ярилцлага хийв.
- **11 дүгээр сарын 7** Удирдлагын багийн 15 ажилтан "Компанийн засаглал" сургалтанд сууж, итгэмжлэгдсэн сертификаттай болов.
- **11 дүгээр сарын 11** Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал Эндрью Вүдлэй Техник Технологийн Дээд Сургуульд зочлов.
- **11 дүгээр сарын 23** Ард Санхүүгийн Нэгдэл Хаалттай Хувьцаат компани боллоо.

- **11 дүгээр сарын 30** ТУЗ-ийн ээлжит хурал боллоо. Хувьцаа эзэмшигчиддээ гэрчилгээг нь гардуулж эхэллээ.
- **12 дугаар сарын 3** Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулан, хамтран ажиллаж эхлэв.
- **12 дугаар сарын 6** Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг олон нийтэд танилцуулах арга хэмжээг Тэнгис кино театрт зохион байгуулав. Охин компаниуд нэгдсэн зохион байгуулалтан дор оролцов.
- **12 дугаар сарын 10** Ардын тамирчин нэгээр нэмэгдэж, Монголын пара цанын шигшээ багийн тамирчин Б.Ганболдын ДАШТ, Пара Олимпид бэлдэж, оролцоход нь тусалцаа үзүүлэхээр болов.
- **12 дугаар сарын 19** Монгол Улсын болон ОХУ-ын Буриад улсын гавьяат жүжигчин Г.Ариунбаатарын "Монгол Сонгодог 2" тоглолтын ивээн тэтгэгчээр ажиллав.
- **12 дугаар сарын 23** Монгол Шуудангийн хувьчлалын тендер зарлагдлаа.
- **12 дугаар сарын 24** Ард Холдингсын хамт олны Шинэ Жилийн Цэнгүүн зохиогдов.
- **12 дугаар сарын 25** Бизнес мэдээний цахим портал www.richtopia.com-оос гаргадаг "Дэлхийн хамгийн нөлөө бүхий 500 Гүйцэтгэх захирал (CEO)" жагсаалтын 241 дүгээр байранд Гүйцэтгэх захирал Ч.Ганхуягийн нэр бичигдлээ.

Гүйцэтгэлийн тайлан

2015 он Монгол Улсын эдийн засгийн хувьд дахин нэгэн амаргүй жил болж өнгөрлөө. Дэлхий нийтийн улстөр, эдийн засгийн тогтворгүй байдал, БНХАУ-ын эдийн засгийн удаашралаас үүдэлтэй уул уурхайн түүхий эдийн үнийн уналт Монголын эдийн засгийн өсөлтийг сүүлийн 5 жилийн доод түвшинд аваачлаа. Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 20 жилд хүрч байгаагүй дээд түвшиндээ хүрч, Монгол төгрөг түүхийнхээ хамгийн доод цэгт хүрч суларлаа. Монгол руу чиглэсэн гадаад хөрөнгө оруулалт үндсэндээ зогсож, манай уул уурхайтай холбоотой бүх хувьцааны ханш шаланд унав. 2016 оны хувьд эдийн засаг үндсэндээ өсөлтгүй болох төлөвтэй байгааг олон улсын санхүүгийн байгууллагууд анхааруулж эхэллээ.



2015 онд Ард Санхүүгийн Нэгдэл нэрийн дор нэгдсэн хамт олон хүндрэл бэрхшээлийг ажралгүй, зорьж төлөвлөсөн олон ажлаа эрчимжүүлэн зах зээлд нээгдэж байгаа шинэ боломжийг эрэлхийлж, амжилт бүтээлээр дүүрэн ажилласан болно.

Бидний олон жил мөрөөдөж, та бүхэнд танилцуулж, үндэс суурийг нь тавьж ажилласан дөрвөн том ажил амжилттай хэрэгжиж, биеллээ олов.

1. Нэгдүгээрт, Ард Санхүүгийн Нэгдэл нь Үнэт Цаасны Төлбөр Тооцоо, Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТТХТ)-д бүртгэлтэй Хаалттай хувьцаат компани болж өөрийн хуулийн статусаа өөрчилж

чадлаа. ҮЦТТХТ-д амжилттай бүртгүүлснээр бид Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй арилждаг анхны санхүүгийн нэгдэл компани болоход нэг алхмын зайнд дөхөн очлоо. Энэ нь зах зээлд эерэг дохио болж, зөвхөн нээлттэйгээс хаалттай руу, хувьцаат компаниас хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэр рүү шилжиж ирсэн сүүлийн 20 жилийн хандлагыг сөрсөн, олон түмний дунд шинэ итгэлийг бий болгосон үйл явдал болов. Үүнийг дагаад ч манай хувьцаа эзэмшигчдийн тоо өнгөрсөн 5 жилийн туршид бууран 300-аас доошоо ороод байсан бол 2015 оны сүүлчээр эргэн өсч, он дуусах мөчид эргээд 600 руу очив. Бид оны эхэнд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Жинст Увс ХК-ийн 84.6 хувийг блок арилжаагаар худалдаж авч



чадсан нь бидэнд олон нийтийн компани болох нэгэн шинэ арга замыг нээх боломжийг гаргаж өгч байна. Манай ТУЗ, хувь нийлүүлэгчид 2016 онд компанийг нээлттэй болгож Монголын нийт ард түмэн банк, санхүүгийнхээ салбарт хөрөнгө оруулж, эзэн нь болох боломжийг олгож, Ард Санхүүгийн Нэгдэл шинэ хөрөнгөө Монголын Хөрөнгийн Бирж дээрээс босгох шийдвэрийг гаргахад бэлэн боллоо.

2. Хоёрдугаарт, бид сүүлийн хоёр жил уйгагүй хөөцөлдсөн хөрөнгийн сангийн менежментийн тусгай зөвшөөрөл гарахад бэлэн болж, хөрөнгө оруулалтын сангийн менежментийн ажлыг эхлүүлж чадлаа. Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2016 он гараад үүсгэн байгуулагдаж, хамтын хөрөнгө оруулалтын сан болох шийдвэр гарган эхний хөрөнгө оруулалтаа хийсэн бол түүхэн ИАЙТи нэрээр хөрөнгө оруулалтын хувийн сан байгуулж, стратегийн бус хөрөнгөө шилжүүлэх ажлыг мөн гүйцэлдүүлэхэд бид бэлэн болж, 2013 онд үйл ажиллагааг нь зогсоож, түр Ард Активд шилжүүлээд байсан хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг хуучин (МТНД) нэрэн дор нь эхлүүлэх боломжтой боллоо. Хамтын болон

хувийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн сангийн удирдлагыг хэрэгжүүлснээр бид Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулаад зогсохгүй компанийн эрхэм зорилгын хүрээнд жижиг хөрөнгө оруулагчдад мэргэжлийн байгууллагатай хамтран хөрөнгө оруулах боломжийг нээж өгч, багцын хөрөнгө оруулах, хөрөнгөө арвижуулах боломжийг хангах юм. Үйл ажиллагаагаа 2007 оноос эхлүүлж, 2013 онд зогсоосон Монголын Тэтгэврийн Нэгдсэн Данс ХХК-ийн үйл ажиллагааг шинээр эхлүүлж, Ард Активд шилжүүлээд байсан тэтгэврийн дансны үйлчилгээг хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр эхлүүлэх ажлыг бид төлөвлөөд байна.

Ард Менежмент компанийн тусгай зөвшөөрөл Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2016 оны 2 дугаар сарын 24-ний өдөр гарлаа. Ард Холдингсын зүгээс 2015 оны сүүлчээр энэхүү компанийг капиталжуулах 100 сая төгрөгийг данс руу нь шилжүүлсэн болно.

3. Гуравдугаарт, ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцааг арилжих шийдвэрийг манай ТУЗ гаргасан бол гүйцэтгэх удирдлага түүнийг нь чадамгай гүйцэтгэв. Ингэснээр бид түүхэн нэг эх сурвалжтай компаниасаа бүрмөсөн салж, зах зээл дээр шууд өрсөлдөх байр сууринд шилжин очлоо. Энэ үйл явц нь өөрөө сүүлийн 3 жил үргэлжилсэн бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл, түүний манлай компани болох ХасБанк, бусад компаниудыг санаачилж, үүсгэн байгуулах үйл явцад хуримтлуулсан туршлагыг бид шууд ашиглаад зогсохгүй, тэнд хийж амжаагүй зарим нэг санааг ажил хэрэг болгох боломж бидэнд нээгдэж байна. Орж ирсэн мөнгөнөөс бид өөрийн 20.9 орчим хувийг эзэмшигчдээс 2016 оны нэгдүгээр сард нэгж хувьцааг 1,500 төгрөгөөр үнэлэн буцаан худалдан авсан нь манай нэгж хувьцааны үнэлгээнд 7.5 хувийн эерэг нөлөө үзүүллээ.
4. Дөрөвдүгээрт, 95 жилийн түүхтэй Монгол Шуудан Компанийн хувьчлалыг оны сүүлчээр Засгийн Газраас зарлаж, тус компанийн 34 хувийг нийтэд нээлттэй арилжаалан босгосон мөнгийг Монгол Шуудангийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зарцуулах нөхцөлтэйгээр явууллаа. Үүний дагуу гүйцэтгэх удирдлага шаламгай ажиллаж, 2016 оны нэгдүгээр сард болсон хувьчлалд амжилттай оролцлоо. Бидний гаргасан шийдвэрийг манай ТУЗ-ийн гишүүд дэмжин Монголын Хөрөнгийн

Гүйцэтгэлийн тайлан

Биржээр нээлттэй явагдсан арилжаанаас Ард Холдингс нийт 17,309,974 ширхэг буюу 17.38 хувийг нь авч чадсан бол үлдсэн 16 гаруй хувийг 350 орчим жижиг хөрөнгө оруулагчид авсан юм. Олон нийтэд зарлагдсан хувьцаанд хоёр дахин илүү их захиалга ирсэн нь хөрөнгийн зах зээлд боломж байгааг илтгэсэн үйл явдал боллоо. Ингээд 2005 оноос хойш бидний зорьж ажилласан нэгэн том ажил амжилттай хэрэгжлээ гэж бид дүгнэж байна. 2016 оны 3 дугаар сард зарлагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас Ж.Оюунгэрэл, Ч.Ганхуяг нар шинэ хувьцаа эзэмшигчдийг төлөөлж Монгол Шуудангийн ТУЗ-д ажиллах болсон бол хараат бус гишүүнээр Гацуурт компанийн Ерөнхийлөгч Л.Чинбат сонгогдсон нь зах зээлд эерэг дохио болов.


Маркетинг, олон нийт сурталчилгааны ажил, нийгмийн хариуцлагын чиглэлээр арга хэмжээг бид өнгөрсөн жил идэвхжүүлж ажилласан бөгөөд энэ нь Ард нэрийн дор нэгдээд байгаа компаниудын ребрэндингийг амжилттай хийх, олон нийтэд хувьцаагаа санал болгоход бэлтгэл болох зорилготой байсан болно. Бидний зохион байгуулж, оролцсон зарим арга хэмжээний талаар та энэ тайлангаас олж мэдэж болно.

Хэвлэх Үйлдвэрийн барилгын хувьчлалд олон нийтийн оролцоог хангаж оролцох санаачлага амжилттай явагдаж, биднийг зах зээл эерэгээр хүлээж авахыг баталж чадлаа. 12 дугаар сарын 6-ны өдөр Ард Холдингсыг олон нийтэд танилцуулах арга хэмжээг Тэнгис кино театрт анх зохион байгуулж, охин компаниуд нэгдсэн



зохион байгуулалтан дор амжилттай оролцлоо. Энэ үйл явдлын дараа Ард Холдингсын жижиг хувьцаа эзэмшигчдийн хооронд хувьцааны арилжаа идэвхжиж, 2015 оны хувьд нийт 3,800,391 ширхэг хувьцааны арилжаа явагдсаныг Ард Секюритизээр дамжуулан хийлээ. Оны эхээр 300 хүрэхгүй хувьцаа эзэмшигчид 600-гаад болж нэмэгдсэн нь бидэнд зах зээлийн зүгээс их итгэл хүлээлгэж, өндөр хүлээлт байгаагийн илрэл гэж бид дүгнэж байна.

Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбооны ажлыг бид тууштай дэмжин ажилласаар ирсэн бөгөөд Төв, Зүүн, Баруун бүсүүдийн хурлыг ондоо багтаж зохион байгууллаа. Баян-Өлгий аймгийн төвийн Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-д гишүүнээр элсэж, нийт сумын 12 хоршооны гишүүн хамтаар



аймгийн хэмжээнд Холбооны анхны салбар хороог байгууллаа. Ард Кредит-ээс холбооны гишүүн 19 хоршоонд 378 сая төгрөгийн бөөний зээлийг олгосон байна. Мөн Тэнгэр Системс-ийн GeniusBanker 4.0 программыг 40 гишүүн хоршоо үйл ажиллагаандаа ашиглаж эхэллээ. Цаашид үндэсний хэмжээний ХЗХ-дын нэгдсэн сүлжээг орчин үеийн технологи дээр үндэслэн бий болгож, нэгдсэн санхүүгийн сүлжээгээр нийт гишүүддээ хүрч ажиллах хэтийн зорилготойгоор ажиллаж байна.

Охин компаниудын ээлжит ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хийж, цаг үеийн асуудлаар шийдвэрүүд гаргаж ажиллалаа. Ард Даатгал компанийн удирдлагад өөрчлөлт

оруулж Гүйцэтгэх Захирлаар нь Арьяасүрэнгийн Батболдыг томилж ажиллуулсан нь нүдээ олсон зөв шийдвэр болсныг компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгээс харж болно. Ард Даатгалын хувьд Монгол Улсад өнөөдөр тулгараад байгаа эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг амжилттай даван туулах боломжийг бид бүрдүүлж ажилласан гэж дүгнэж болно.

Манай хөрөнгө оруулалттай Өнгөт Хэвлэлийн түүхэн байр руу өөрийн оффисыг нүүлгэсэн нь Компанийн ребрэндинг хийж, олон нийтэд өөрийгөө ойртуулан таниулах зорилготой шийдвэр байсан ч бидний цаашдын стратегид онцгой үүрэг гүйцэтгэх компаниудын удирдлагын баг бие биенээ түшин, бүрэлдэн бэхжих боломжийг олгосон давуу талтай байлаа.

Санхүүгийн гүйцэтгэл

Нийт актив 34.6 тэрбум төгрөг болж өссөн бол манай цэвэр ашиг 3.2 тэрбум төгрөг болж, нэгж хувьцааны үнэлгээ 2,176 төгрөг боллоо. BDO Аудит компанийн зүгээс манай компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хоёрдахь удаагаа гаргасан болно.



Баланс дээр гарсан хамгийн том өөрчлөлтөнд ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцааг худалдах ажиллагаа явагдаж, орлогыг нь авлагаар бүртгэсэн харагдаж байгаа бол нөгөө талдаа өөрийн 20 гаруй хувийг хоёр хувьцаа эзэмшигчээс худалдаж авах гэрээний дагуу бид тэрхүү мөнгийг нь өглөгөөр бүртгэсэн байгаа болно. Apollo Ventures, UBIG хоёрын хувьцааг бид халааслах бус Ард Секюритизд тусгай нөхцөлтэй зээл өгч, худалдан авсан нь манай үлдэгдэл тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх болно.

Хойшлогдсон татварын өглөгийг бид эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн дагуу барагдуулж, нийт 6.7 тэрбум төгрөгний давуу байдлыг өөрийн хувь нийлүүлэгчдэд бий болгож чадсан нь манай балансад туссан байна.

2015 оны хамгийн том амжилт бол бид 2007 оноос хойш анх удаагаа огт өргүй, харин цэвэр авлагатай компани болж чадсанд оршино.

Бид 2015 оны эхээр Өнгөт Хэвлэлийн байр руу нүүн орж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд анх тооцоолж байснаар илүү хөндлөнгийн байгууллагуудад хөлслөх ажиллагаа амжилттай явагдсангүй. Ингэснээр бидний төсөөлж байсан түрээсийн орлого төлөвлөгөөндөө хүрээгүй бөгөөд энэ нь манай цэвэр орлогод хамгийн том сөрөг нөлөө үзүүлсэн бол зардал талдаа Ард Санхүүгийн Нэгдэлийн реклам, зар сурталчилгаа, нийгмийн хариуцлагын болон тусгай арга хэмжээний зардал хамгийн их хэтрэлттэй гарсан юм.

2015 онд манай хөрөнгө оруулалтын орлого 4 тэрбум төгрөгт хүрсэн нь манай татварын дараах ашиг болох 3.2 тэрбум төгрөгт хамгийн том нөлөө үзүүлсэн болно. ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцааны арилжаа он гарч явагдан гадаад валютын ханшийн зөрүүний ашиг болох 900 орчим сая төгрөгийг бид 2016 оны эхний улиралд хүлээн зөвшөөрч бүртгэлээ. 2015 онд Ард Холдингс улсын татварт нийт 291 сая төгрөгийн орлогын албан татвар төвлөрүүлэв.



Бид Ард Кредит, Ард Даатгал болон Техник Технологийн Дээд Сургуулиас нийт 206.5 сая төгрөгийг ноогдол ашгаар төвлөрүүлсэн бол зээлийн хүүгийн орлогоор 210.8 саяыг олж чадлаа. 2015 онд бид шинээр түрээсийн орлоготой болж, нийт 130.7 сая төгрөг оллоо. Менежментийн орлого төлөвлөснөөс тасарч 109.2 саяыг бидэнд авчирсан нь зарим компаниудын ажил жигдрээгүй, тодорхой санхүүгийн бэрхшээлүүд учирч ажилласантай холбоотой.

Бид гадаад валютын ханшийн зөрүүнээс 89 сая төгрөгийг ашгаар бүртгэж авсан байна.

Цалингийн зардалд 245.9 сая төгрөг гарсан нь өмнөх оны 390.2 саяас нилээд хэмнэж ажилласан гэдгийг харуулна. Хүүгийн зардал 561.8 сая гарч байсан бол 2015 оны хувьд бид зээлүүдээ амжилттай хааж чадсан тул 87.2 сая төгрөг санхүүгийн эх үүсвэрийн зардалд бүртгэгдлээ.

Үйл ажиллагааны зардал 507.3 сая төгрөгөөс 890 сая төгрөг болж өссөн гол шалтгаан нь манай шинэ төв албаны байрны түрээсийн зардал 286.7 сая төгрөг болж өссөн нь нөлөөлсөн байна. Ашиглалтын зардал 110 сая төгрөгийн түвшинд тогтвортой байсан бол томилолтын зардал 86.3 саяас 41.9 сая болтол буурсан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал 138.2 саяас 83.5 сая төгрөг болсон нь бид Ард Секюритиз, Уайлд Дижитал Эйженсигээр олон ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсэн нь нөлөөлжээ.


Мөн хөрөнгийн зах зээл рүү гарах ажлын бэлтгэл ажил эрчимжиж бид маркетинг, зар сурталчилгаанд 109.2 саяыг зарцуулсан бол тусгай арга хэмжээ, нийгмийн хариуцлагын чиглэлд 147.2 сая төгрөг гаргаж ажиллалаа.

Бид Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох хэсэгт заасны дагуу тайлангаа тохируулан бэлтгэж, татварын албанд тушааснаар хойшлогдсон татварын өглөггүй болж, Компанийн тэнцлийг олон улсын аудитын тайланд тусгагдсан хэмжээнд аваачив. Та бүхэн манай аудитлагдсан тайлантай ardhholdings.com сайтаар орж танилцаарай.

2014 онд гаргасан шийдвэрийн дагуу бид эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор цалин, орон тоогоо хамгийн доод түвшинд барьж ажиллаж байсан бол оны 2015 оны сүүл рүү Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Маркетингийн захирал, Хөрөнгө оруулагчийн харилцааны менежер зэрэг орон тоог бий болгож, 2016 онд Дотоод аудитор шалгаруулан ажиллуулахаар боллоо. Ч.Ганзориг Санхүү эрхэлсэн захирлын үүргийг давхар гүйцэтгэж ирсэн бөгөөд А.Батболд Хуулийн зөвлөхийг хавсран гүйцэтгэлээ. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Ө.Батсайхан 2016 оны эхнээс ажиллаж эхэлсэн болно.

Бид өөрийн хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд идэвхтэй байр сууринаас хандаж, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож ирсэн бөгөөд тэдний санхүүгийн байдлыг сайжруулахад ихээхэн анхаарч ажилласан болно. Ард Кредит болон Ард Даатгал дээр хуримтлагдаад байсан ужгирсан авлагуудыг хаахад Ард Холдингс шийдвэрлэх үүрэгтэй оролцож, тэдгээрийг амжилттай шийдвэрлэж, балансыг нь цэвэрлэлээ.

Хөрөнгө оруулалтын бүтэц




Хөрөнгө оруулалтын түүх, өгөөж

	Хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтын хугацаа		Үнэлгээ (₮)	Ашиг (сая төг)		Хөрөнгө оруулалтын өгөөж		Жилийн дундаж
	Авсан хувь	Авсан он	Зарсан он		Хэрэгжсэн (₮)	Хэрэгжээгүй (₮)	Хэрэгжсэн (%)	Хэрэгжээгүй (%)	
Худалдсан хөрөнгө оруулалт									
Прайм Даатгал	50	2008	2010		850.0	-	131		55
Актив Зууч	50	2009	2012		25.8	-	26		7
Ай Консепт	50	2011	2012		138.7	-	87		80
Арвай Алтернатив	100	2010	2012		-	-	0		0
ТэнГэр Лиг	100	2008	2013		-	-	0		0
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл	7	2008	2016	-	15,031.7	-	525		75
Арвай Капитал	100	2010	2015	-	(10.0)	-	-100		-20
Одоо байгаа хөрөнгө оруулалт									
ТТДС	50	2008		9,824.9		7,901.5		411	
Ард Даатгал	33	2014		6,337.2		(300.0)		-5	
Ард Кредит	50	2015		1,852.9		600.0		48	
Ард Секюритиз	100	2009		983.0		(256.1)		-21	
Номын Хишиг	20	2011		1,382.4		333.7		32	
Бусад	0			464.4		174.9		60	
Нийт				20,844.8		8,629.0		70	
Шинэ хөрөнгө оруулалт									
Монгол Шуудан	17	2016		5,279.5		2,077.2		65	

Хувьцаа эзэмшигчдийн өгөөж (жишээ)

Нэр	Хийсэн	Худалдсан	Ашиг (сая төгрөг)	Нийт өгөөж (%)	Хугацаа (жил)	Дундаж өгөөж (%)
Хөрөнгө оруулагч А	2001	2011	39.2	1,397	10	140
Хөрөнгө оруулагч Б	2001	2012	198.7	2,550	11	232
Хөрөнгө оруулагч В	2001	2012	5,665.7	657	11	60
Хөрөнгө оруулагч Г	2001	2015	2,669.9	1,400	6	233


Хувьцаа эзэмшигчийн бүтэц



*Ард Секюритиз зарим хувьцаа эзэмшигчээс худалдан авсан 3,708,005 ширхэг хувьцаа саналын эрхгүй болно.

2015 оны арилжааны мэдээлэл

2015 онд 7.8 тэрбум төгрөгийн 5.3 сая ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 70 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Компани хэлбэрээ өөрчилж Хувьцаат Компани болсонтой холбоотойгоор 2015 оны 8 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хувьцааны арилжаа, шилжүүлэг явагдаагүй байна. 2015 оны сүүлээс компанийн хувьцаа идэвхитэй арилжаалагдаж эхэлсэн бөгөөд 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 860.3 мянга хувьцаа арилжаалагдав. Энэ нь өмнөх оны мөн үеэс 68.6 хувиар өссөн үзүүлэлт юм. 2015 онд компанийн хувьцааны үнэ 1,500 төгрөгөөр хаагдсан байна.



Цаашдын зорилго, төлөвлөгөө

Ард Санхүүгийн Нэгдэл Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан Монголын иргэн бүрт өөрийн өдөр тутамдаа үйлчлүүлдэг банк, санхүүгийн байгууллагынхаа хувийг эзэмших, ашиг өгөөжийг нь хүртээх том зорилго руугаа тууштай тэмүүлнэ. Компанийн үйл ажиллагааг илүү ил тод, санхүүгийн хувьд тогтвортой байлгаж, өөрийн удирдлага доорх компаниудын засаглал, удирдлагыг төгөлдөршүүлэх ажлыг бид эрчийг нь алдалгүй үргэлжлүүлэх болно. Бид багц дахь бүх компанийнхаа үнэ цэнийг өсгөх, үйл ажиллагааны уялдааг хангах, харилцан шүтэлцээг бий болгож, боловсон хүчнийг шат бүрт хүчирхэгжүүлэх ажлыг гүйцэтгэж ажиллана. Байгууллагын цоо шинэ соёлыг бий болгож төлөвшүүлэх бөгөөд бид зах зээлд манлайлах байр сууринд очихыг зорино.

Энэ жил бид Ард Кредитэд нэмж 1 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлэх төлөвтэй байгаа бөгөөд Ард Кредитыг арилжааны банкны бүхий л ажил үйлчилгээг эрхэлдэг хэмжээнд хүргэх ажлыг тууштай үргэлжлүүлж, Монголын анхны нээлттэй хувьцаат компани хэлбэртэй банк бус санхүүгийн компани болгох ажлыг судална.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавьсан шаардлагын дагуу бид Ард Даатгалын өөрийн хөрөнгийг 1.5 тэрбумаар нэмэгдүүлэх ёстой. Ард Даатгал анхны нээлттэй даатгалын компани болох боломжтойгоос гадна цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ, түгээлтийн сувгийг даатгалын салбарт анхлан нэвтрүүлж, хөрөнгийн удирдлагын чадавхийг хөгжүүлж ажиллана.

Бид тэтгэврийн сангийн үйл ажиллагааг ойрын хугацаанд хуулийн хүрээнд эхлүүлэх боломжтой боллоо. Ард Актив харин гишүүдийн хүрээндээ үйл ажиллагаагаа эрхлэх хадгаламж зээлийн хоршооны статусаа хадгалж, Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой нягт уялдаатай ажиллаж эхлэх болно.

Ард Секюритизын ажил 2015 онд тогтворжсон бол манай багцын хамгийн сайн санхүүгийн гүйцэтгэлтэй компани болгох ажлыг бид ирэх нэг жилийн дотор хийхээр зорьж байна.

Ард Менежментийн үйл ажиллагааг эхлүүлж, зөв үндэс суурийг тавихад анхаарч, эхний ээлжинд EIT, Хөрөнгө Оруулагч Үндэстэн, МТНД-г удирдуулахаар төлөвлөлөө.



Тайлангийн хугацааны удаах үйл явдал

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл дэх үлдсэн 4.26 хувиа арилжаалах ажил дүгнэгдэж, арилжааны дүн болох 12.4 тэрбум төгрөг бүхлээрээ манай дансанд орж ирэв.

Монгол Улсын Засгийн Газраас зарласан Монгол Шуудан Компанийн хувьчлалд амжилттай оролцож, 3.3 тэрбум төгрөгөөр бид тус компанийн 17.38 хувийг Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар худалдаж авлаа. Нэгж хувьцааны хувьчлалын үнэ 185 төгрөг байсан бол 3 дугаар сарын эхээр 325 төгрөг хүрсэн байна. 3 дугаар сарын 2-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болж, Ж.Оюунгэрэл, Ч.Ганхуяг нар хувийн хэвшлийн 34 хувийн төлөөллийг хэрэгжүүлэхээр сонгогдсон бол хараат бус гишүүнээр 3, Засгийн Газрын төлөөллийг хэрэгжүүлэхээр 4 хүн сонгогдов. Шинээр бүрэлдсэн ТУЗ хуралдаж, ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаа 4 дүгээр сард зарлалаа.

Ард Холдингс хамгийн том 2 хувьцаа эзэмшигч болох UBIG, Apollo Ventures нар хувьцаагаа 1,500 төгрөгөөр компанид буцаан худалдах 2014 оны 12 дугаар сарын гэрээний дагуу нийт 5.4 тэрбум төгрөгийг төлбөрт нь шилжүүлж, гүйлгээг хийлээ. Энэхүү 2 үйл явдлын дараа 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар Ард Холдингсын үнэлгээ 31 орчим тэрбум төгрөг болж, манай нэгж хувьцааны үнэлгээ 2,024-иас 2,329.5 төгрөг болж өслөө.

Манай менежментийн компанийн дор ажиллах Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК-ийг олон нийтийн дунд мөнгө босгох байдлаар бид үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээ.



Ард Даатгал

Өнгөрсөн жил Ард Даатгал ХХК нь нийт 9 тэрбум гаруй төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж, 2 орчим тэрбум төгрөгийг давхар даатгалд төлж, 7 орчим тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлоготой ажиллалаа. Даатгалын үндсэн үзүүлэлтээр Ард Даатгал нь салбарын шилдэг 5 компанийн дотор багтаж ТОП 5 даатгагчийн нэг гэсэн байр сууриа баталгаажууллаа. 2015 оны 8 дугаар сард компанийн гүйцэтгэх захирлаар А.Батболдыг томилж, СЗХ-ноос түүнийг 2016 оны эхээр баталгаажууллаа.

Ард Даатгал ХХК нь төв компанийн борлуулалтын менежерүүд болон нийт 25 салбар, 380 гаруй даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан иргэд, ААН-үүдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, худалдааны салбаруудад санхүүгийн, эд хөрөнгийн, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын, гэнэтийн ослын гэх мэт даатгалын бүх төрлийн үйлчилгээг хүргэж ажиллав.

2015 онд факультатив давхар даатгалын төрлүүдээр MARSH, AIG, ALLIANZ, UIB, ИНГОССТРАХ давхар даатгагч болон брокеруудтай хамтарч ажиллаа. Мөн AIG болон Allianz компанийн Монгол дахь фронтинг даатгагч компаниар сонгогдон ажиллаж байна.

2015 онд бид 3,828.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож өмнөх оноос 733.3 сая төгрөг буюу 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд 6,000 гаруй нөхөн төлбөрийн хохирлыг Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль, СЗХ-ын журам, заавар, Даатгалын гэрээг үндэслэн барагдуулсан байна. Нийт нөхөн төлбөрийн дийлэнхийг Жолоочийн хариуцлагын албан журмын болон Орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгалын тохиолдлууд эзэлж байна.





2015 оны эцэст компанийн нийт хөрөнгө 8,758.5 сая төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулбал 69.1 сая төгрөг буюу 1 хувиар өссөн байна. 2014 оны эцэст 4,163.4 сая төгрөгийн нөөц сангийн үлдэгдэлтэй байсан бол 2015 оны эцэст 4,531.6 сая төгрөг болж өслөө.


Хөрөнгө оруулалтын орлогын хувьд 580.5 сая төгрөгт хүрч, өмнөх жилийн мөн үеэс 165 сая төгрөгөөр буурсан байна. Хөрөнгө оруулалтын орлого буурсан нь 2015 онд өөрсдийн оффис худалдаж авсантай холбоотой юм.

Тайлант жилийн алдагдал 138 сая төгрөг, өссөн дүнгээр зардлын харьцаа 42 хувь, хохирлын харьцаа 42 хувь, хосолсон харьцаа 84 хувь тус тус гарлаа. 4 дүгээр улирлын байдлаар компанийн төлбөрийн чадварын үзүүлэлт 100.1 хувь байна.

Ард Даатгал нь Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцад томоохон байр суурийг эзэлдэг компани юм. 2015 онд Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Даатгалын 55 хувийг эзэмших болж, компанийн хамгийн том хувьцаа эзэмшигчийн хувьд ТУЗ-ийн Даргыг томилж, хамтран ажиллаж байна. Компанийн нийт ажиллагсад урт хугацааны тэтгэврийн хуримтлал бий болгож, тэтгэврийн сангийн үйлчилгээгээр Ард Актив ХЗХ-той хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллалаа. Мөн группын бусад компанийн харилцагч нарт даатгалын үйлчилгээг санал болгон, огтлолцоо борлуулалт хийхээр ажлын хэсэг байгуулан ажиллаж эхлээд байна.



www.arddaatgal.mn
+(976) 7720 0089
info@arddaatgal.mn



Ард Кредит

2015 онд дэлхийн эдийн засгийн байдал болон дотоодын хүчин зүйлсээс шалтгаалан Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд суларч, хямралын түвшинд ирж байна. Эдийн засгийн уналт нь банк санхүүгийн салбарт шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд банкуудын нийт зээлийн багцын хэмжээ өмнөх оноос 6.5 хувиар буурч 11.7 их наяд төгрөгт хүрч, чанаргүй зээлийн багц өмнөх оноос 2.1 нэгж хувиар өсч 7.1 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр Монгол Улсын бизнесийн орчин таагүй байсан боловч бид компанийн өсөлт болон ашигт ажиллагааг ханган ажиллахын зэрэгцээ компанийн засаглал, хүний нөөц, гадаад харилцаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлэх тал дээр тодорхой ажлуудыг хийж, зах зээл дээрх компанийн байр сууриа бэхжүүлэн ажиллалаа. Компани нийт 8 үндсэн ажилтантайгаар ажилласан бөгөөд нийт хөрөнгийн хэмжээ 37 хувь өсч 4.6 тэрбум, цэвэр зээлийн хэмжээ 38 хувь өсч 3.6 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор бид зээлийн хугацаа хэтрэлтийг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг цаг алдалгүй аван ажилласан бөгөөд чанаргүй зээлийн багцыг 5.2 хувьд барин ажиллалаа. Оны эцэст бид 410 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай гарсан нь 24 хувийн дундаж өөрийн хөрөнгийн өгөөжтэй тэнцэж байна.

2015 онд манай хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч болох Ард Санхүүгийн Нэгдэл хувьцаа эзэмшигч Ч.Ганзориг-оос компанийн нийт гаргасан хувьцааны 8 хувийг худалдан авч 58 хувьтай болсон юм. Энэхүү арилжааг хийхдээ хувьцааны үнэлгээг бүртгэлийн үнийг 2 дахин үржүүлсэн үнээр тооцон авсныг цохон тэмдэглэж байна.


2016 онд эдийн засаг, зах зээлийн ерөнхий байдал сайжрах төлөвгүй байгаа бөгөөд бид компанийн үйл ажиллагааны зардал болон эрсдэлийг аль болох бага хэмжээнд барин ажиллахын зэрэгцээ зах зээл дээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх замаар компанийн төлөвлөгөөт өсөлтийг ханган ажиллахыг зорьж байна. Энэхүү эдийн засгийн хямрал нь компанийн хувьд анхны томоохон сорилт болж байна. Энэ үеийг ашиглан компанийн хүний нөөц, бүтэц, засаглал, эрсдэлийн удирдлага зэрэг цаашид өсөх үндсэн суурийг бэхжүүлж ажиллах шаардлагатай байна. Ингэснээр бид хямралаас илүү хүчтэй болон гарч ирэх бөгөөд эдийн засаг эргээд өсч эхлэх үед бэлэн байх болно.

ARD КРЕДИТ
ББСБ


 www.ardcredit.com
 + (976) 7700-3322
 info@ardcredit.com

CREDIT BANK


Нийт актив (мянган, төгрөг)




Цэвэр зээл (мянган, төгрөг)



Өөрийн хөрөнгө (мянган, төгрөг)



Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (мянган, төгрөг)



Ард Секюритиз

Үнэт цаасны зах зээлийн өсөлт бууралтын аль ч мөчлөгт Ард Секюритиз Үнэт Цаасны компани (ҮЦК) нь найдвартай, тогтвортой үйл ажиллагаа үзүүлдэг гэдгээ баталж, дахин нэг жилийг амжилт, ололт дүүрэн ардаа үдлээ.

2015 онд Монголын эдийн засаг удааширч, хөрөнгө оруулалтууд царцаж, бизнесийн орчин тогтворгүй байж олон үнэт цаасны компаниуд татан буугдсан хэдий ч Ард Секюритиз нь менежментийн зөв бодлого баримтлан үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдээ тасралтгүй өсгөлөө. Тухайлбал, үнэт цаасны данс нээлт 6 дахин өсч харилцагчдын тоо 11970-д хүрсэн бол үнэт цаасны арилжаа 4.6 дахин өсч, 7.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үнэт цаасны арилжааны 99 хувь буюу 7.8 тэрбум төгрөг нь Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьцааны арилжаа байсан бөгөөд энэ нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн бүтээгдэхүүн үйлчилгээ гарвал хувьцаа, бондод хүмүүс хөрөнгө оруулалт хийж чаддаг гэдгийг харуулсан томоохон үйл явдал байлаа.


Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдвэрлэх ажлын хүрээнд Ард Секюритиз нь 34 тэрбум төгрөгийн үнэлгээтэй Ард Санхүүгийн Нэгдэл компанийн хэлбэрийг өөрчлөн Хувьцаат компани болгон ҮЦТТТХТ-д амжилттай бүртгүүлэв. Мөн тус компанийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Жинст-Увс ХК-ийн хувьцааг худалдан авахад зуучилж, МХБ-д бүртгүүлэх үйл ажиллагааг хялбаршуулахад том алхам хийв. Бид Ард Санхүүгийн Нэгдэлтэй хамтарч ажиллахын зэрэгцээ барилга, уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтарч ажиллан, 5.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөв.

2015 онд компани нь 233.0 сая төгрөгийн орлого, 154.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажиллаж, үндсэн үйл ажиллагааны ашиг 78.1 сая төгрөгт хүрсэн. Энэ нь өмнө оны мөн үеэс 1.3 дахин өссөн үзүүлэлт юм. Гэвч урьд жилүүдэд хүлээн зөвшөөрсөн авлага төлөгдөх боломжгүй болсноос компанийн татварын дараах алдагдал 215.1 сая төгрөг болсон байна.


 www.ardsec.com
 +(976) 11 321899
 info@ardsec.com

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК


Харилцагч




Арилжаа



Орлого (мянган, төгрөг)



Баланс (мянган, төгрөг)



Ард АКТИВ

Өнгөрсөн 2015 он бидний хувьд бүтэц бүрэлдэхүүний хувьд томоохон өөрчлөлттэй, үйл ажиллагааны түвшинг дахин нэг шатаар дэвшүүлсэн, үр бүтээл, сорилт дүүрэн жил болж өнгөрлөө.

Монголдоо анхдагч хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг залгамжлан ажиллаж буй манай байгууллагын хувьд уг бүтээгдэхүүнийг нийгэмд таниулж, түүний ирээдүйн өндөр өгөөжийг харилцагчиддаа мэдрүүлэх нь гол зорилго болсоор ирсэн юм. Тиймээс ч бид харилцагч болон гишүүддээ санхүүгийн сургалт явуулж, тэдний хувийн санхүүгийн зөвлөхөөр ажиллан аливаа санхүүгийн асуудлыг шийдэж, хамтран ажиллаж ирлээ.

2015 онд манай нийт гишүүдийн тоо 56 хувиар, нийт активын хэмжээ 49.5 хувиар тус тус өссөн нь бид зорилгодоо хүрэх эхлэлээ тавьсныг харуулж байна.

Нөгөө талаас 2015 онд байгууллагын бүтэц бүрэлдэхүүнээ нэмэгдүүлж, чадварлаг хамт олныг нэгтгэн засаглалаа бэхжүүлж, дотоод хяналтаа сайжруулж, эрсдэлийн удирдлагаа шинэ түвшинд хүргэсэн юм. Үүний үр дүнд манай зээлийн багцын чанар сайжирч 99.8 хувьд хүрээд байна.

Гишүүд болон харилцагчдаа түргэн шуурхай үйлчилгээгээр хангахын тулд дэвшилтэт технологи, олон нийтийн мэдээллийн сүлжээнд суурилсан цахим үйлчилгээг нэвтрүүлсэн нь цаг үедээ тохирсон шийдэл байж чадсан.


Бид цаашид Хувийн Тэтгэврийн Сангийн үйл ажиллагааг өөрсдийн орны онцлог, нөхцөл байдалд тохируулан хөгжүүлж, иргэд болон харилцагчиддаа санхүүгийн томоохон бүтээгдэхүүний сонголтыг бий болгон ажиллахаар зорьж байна.




www.ardassets.com
 +(976) 7707-8080
info@ardassets.com

ARD АКТИВ
ХЗХ


Гишүүдийн тоо




Нийт хөрөнгө (сая, төгрөг)



Зээлийн багц (сая, төгрөг)



Хадгаламж (сая, төгрөг)



Техник Технологийн Дээд Сургууль

2015 онд Хүчтэй, Хамтдаа уриан дор Ард Холдингс болон түүний хөрөнгө оруулалт бүхий компани нэгжтэй хамтран ажилласанаар ТТДС нь байгууллагын хувьд сайн засаглалын хэв шинжийг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэх, эдийн засаг санхүүгийн хямрал болон ЕБС-н төгсөгчдийн тоо цөөрсөн шалтгаанаас элсэгчдийн тоо огцом буурсан зэрэг асуудлыг хамтын хүчээр даван туулах зорилготойгоор ажиллаж байна.

Бид "Шинэ Яармаг" орон сууцны цогцолбор хорооллын бүтээн байгуулалтын ажилд нэн шаардлагатай мэргэжлүүдээр богино хугацааны сургалт ээлж дараалан зохион байгуулж барилгын засал чимэглэл, барилгын мужаан, бетон арматурчин мэргэжлүүдээр 60 иргэнийг сурган төгсгөлөө.

2015 оны 8 сард Бразил улсын Сан-Паулу хотод зохиогдсон "Дэлхийн ур чадвар-2015" тэмцээнд ТТДС-ийн төгсөгчид гагнуур, мужаан, тогооч 3 мэргэжлээр эх орноо төлөөлөн амжилттай оролцсон ба Монгол Коосэн сургуулийн загвар ангийн 3 оюутан Японы Коосэн сургуульд 5 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцах тэтгэлэгт хамрагдав.

Глобал Шэйперс нийгэмлэгээс санаачилж "Оюу толгой" ХХК-ийн санхүүжүүлсэн "Гэр төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлэн Улаанбаатар хотын 60 дунд сургуульд түгээсэн. Энэхүү бэлэглэсэн гэрийг манай багш, оюутнууд амжилттай хийж, хүлээлгэж өглөө. Тус төслийг санхүүжүүлсэн "Оюу толгой" ХХК-ийн Ерөнхийлөгч Эндрю Вүүдл өнгөрөгч 11 сард сургуульд зочиллоо. Мөн Японы Сумитомо корпорацитай хамтран төсөл хэрэгжүүлж байна.

Сургуулийн нийт багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч Ард Активд гишүүнээр элсэж, урт хугацааны тэтгэврийн хадгаламж нээснээр сар бүр хуримтлал үүсгэж эхэллээ. Ард Кредитээс тус сургуулийн оюутанд зориулан зээлийн бүтээгдэхүүн гарган хамтран ажиллаж байна.




www.iet.mn
 +(976) 7000-7631
mailto@iet.mn




Техник Технологийн
Дээд сургууль


Хөрөнгө (сая, төгрөг)




Эзний өмч (сая, төгрөг)



Орлого (сая, төгрөг)



Ашиг (сая, төгрөг)



ТэнГэр Системс

Манай компанийн хувьд 2015 онд компанийн урт хугацааны төлөвлөгөөгөө баталж ажиллалаа. Энэхүү төлөвлөгөөний дагуу бид өнөөдөр санал болгож байгаа бүтээгдэхүүнээ шинэчилж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод хүргэж байгаа үйлчилгээгээ сайжруулан зах зээл дээр тэргүүлэх байранд гарахаар зорин ажиллаж эхэллээ. Бид санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулж, авлага, өр төлбөр барагдуулах тал дээр тодорхой арга хэмжээг авч ажилласан бөгөөд зарим шинэ програм хангамжийн шийдлийг боловсруулахаар боллоо. Оны сүүлчээр ТэнГэр Системс хүний нөөцийн чадавхиа бэхжүүлж, чадварлаг ажиллах хүчнээр багаа сэлбэж, орон тоог нэгээр нэмэгдүүлсэн юм.

2003 онд анх боловсруулж байсан хадгаламж зээлийн хоршоодын хэрэглэдэг гол бүтээгдэхүүн болох ЖениусБанкер програмыг өмнөх хувилбарын алдаа дутагдлыг сайжруулан хөгжүүлэлт хийн амжилттайгаар нэвтрүүлж эхэлсэн бөгөөд одоогоор Ард Актив ХЗХ туршилтаар ашиглаж байна. Энэ шинэ бүтээгдэхүүнийг 2016 ондоо Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбооны бүх хоршоодод нэвтрүүлж, орлогоо хоёр дахин нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Ард Кредит ББСБ, Ард Актив ХЗХ дээр зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл мессеж хэлбэрээр явуулдаг, дансны хуулгын мэдээллийг электрон шуудангаар явуулдаг програм хангамжийг бид амжилттай нэвтрүүлж ажилласан бол 2016 онд бусад хэрэглэгчидээ санал болгохоор ажиллаж байна.


Бидний дунд өндөр хүлээлт үүсгээд байсан Тербиум банкны удирдлагын систем техникийн шалтгаанаар саатсан хэвээр байна. Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан энэ бүтээгдэхүүний эхний хувилбарыг бэлэн болгож 2016 оны эхний хагаст Ард Кредитэд туршиж эхлүүлэхээр ажиллаж байна.

Шинээр Ард Секюритиз үнэт цаасны компанид үндсэн мэдээллийн систем боловсруулах ажлыг бид эхлүүлсэн болно.




 www.tengersystems.mn
 +(976) 7707-8080
 contact@tengersystems.mn


Программ хэрэглэгчдийн тоо



Санхүүгийн үзүүлэлт (сая, төгрөг)



Орлого зардлын үзүүлэлт (сая, төгрөг)




Номын Хишиг

Номын Хишиг ХХК 2015 онд өөрийн үндсэн үйл ажиллагаа болох үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэн явуулахад анхаарал хандуулан ажиллалаа. Нийт түрээсийн талбайн 30 гаруй хувийг түрээслэж байсан байгууллага түрээсээ зогсоосон учир тухайн талбайг өөр байгууллагад түрээслэхийн тулд багагүй хэмжээний хөрөнгө оруулалт хийж, оны эцсээр холбогдох гэрээ хэлцлийг амжилттай хийлээ. Гэсэн хэдий ч эдийн засгийн гүн хямралтай нөхцөл байдал түрээсийн орлогыг цаг тухай бүр бүрэн төвлөрүүлэх боломжийг олгохгүй байсаар байна.


Цаашид бид барилгынхаа суурийн давхар болон дээврийн хэсгийг өргөтгөж ашиглах, гадна тохижилт, фасадыг шинэчлэх зэрэг ажлуудын төлөвлөгөөг боловсруулж, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр олохоор зорьж ажиллаж байна. Урт хугацаанд бид объектын онцгой буюу хотын төвийн АА зэрэглэлийн байршилаа ашиглан өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийн төслийг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалт босгох зорилт тавин судалгааг үргэлжлүүлж байна.




+ (976) 7711-8894




Нийт хөрөнгө (сая, төгрөг)




Эзний өмч (сая, төгрөг)



Нийт орлого (сая, төгрөг)



Хуримтлагдсан ашиг (сая, төгрөг)



Уайлд Дижитал Эйженси

Бидний хувьд 2015 он хийж бүтээсэн ажил ихтэй, амжилт бүтээл арвин завгүй жил болон өнгөрлөө. Манай улсад хоцрогдоод байгаа дизайн, брэндинг, вэб технологийн салбарыг хөгжүүлж олон улсын стандартыг барьж ажиллах нь бидний гол зорилт байсаар байна. Үүнийг даган хамт олон маань өөрийн ур чадвараа зогсолтгүй дээшлүүлсээр байна.

Үүдмонт Интернэйшнл, Улаанбаатар Хотын Хөгжлийн Корпораци, Гэгээнтэн Энтертайнмент төв, МахониЛинотта зэрэг гадаад болон дотоодын байгууллагуудын цахим орчин дахь өнгө төрхийг цогцоор шийдсэн бөгөөд тэдний ребрэндингийн ажлыг амжилттайгаар гүйцэтгэлээ.

Бид харилцагчиддаа илүү чанартай, ойрхон үйлчилгээг хүргэх арга барилыг нэвтрүүлэн ажилласнаар бат бөх харилцааг бий болгож, харилцагчид маань харилцаагаа улам нягт болгон хамтран ажилласаар байна.


Уайлд цаашид шинээр мобайл болон технологийн шийдэл бүхий бүтээгдэхүүнийг гаргахаар шамдан ажиллаж байна.

WILD




www.wild.agency
+(976) 9191-2678
info@wild.agency


Нийт хөрөнгө (сая, төгрөг)



Орлого (сая, төгрөг)



Эздийн өмч (сая, төгрөг)



Хараат бус аудиторын тайлан

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК -ийн 5-58 дугаар хуудсанд тусгагдсан 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Тусдаа Санхүүгийн Байдлын Тайлан, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн Тусдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан, Тусдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, Тусдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тусдаа санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудыг НББОУС 27, Тусдаа санхүүгийн тайлан -ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Үүнд тусдаа санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг зохион байгуулж ажиллуулан, хэвийн түвшинд сахих; тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх; нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр тусдаа санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь тусдаа санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед тусдаа санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн тусдаа санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан тусдаа санхүүгийн тайлангууд нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, Тусдаа Санхүүгийн Тайлан ("НББОУС 27")-ын дагуу бүх материаллаг талаараа шударгаар илэрхийлсэн байна.

Бусад асуудал

2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай Монгол улсын хуулийг энэ хууль батлагдсан өдрөөс 2016 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хэрэгжүүлэхээр баталсан. Энэ хуулиар 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд хамаарах бүртгүүлээгүй, тайлагнаагүй, мэдүүлээгүй хөрөнгө, орлого, бусад холбогдох зүйлээ сайн дурын үндсэн дээр шинээр бүртгүүлсэн, мэдүүлсэн бол тухайн тайлагнасан зүйл, түүний эх үүсвэр, хэмжээ, үнэ, өртгийг нууцлах ба нотлох баримт болгон ашиглахыг хориглосон. Иймд компани тайлант жилд энэ хуулийн хүрээнд хөрөнгө, орлого, энэ хуульд хамаарах бусад зүйлээ нөхөн тайлагнасан эсэхийг бид үнэлээгүй бөгөөд тайлант жилийн 4 дүгээр сарын 1 ба түүнээс өмнөх тайлант хугацаанд хамаарах аливаа залруулгын ул үндэслэлтэй байдлыг нотлоход зориулсан аливаа аудитын горим гүйцэтгээгүй болно.

Онцлон авч үзэх асуудал

Бид дээр гаргасан аудитын дүгнэлтийн хэлбэрийг өөрчлөлгүйгээр эдгээр санхүүгийн тайланд тусгагдсан охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн тооцооллын асуудлыг онцлон авч үзэж байна. Компани тусдаа санхүүгийн тайлагналын зорилгоор санхүүжигч компаниудад оруулсан хөрөнгө оруулалтаа НББОУС 27, Тусдаа санхүүгийн тайлан–ийн шаардлагад нийцүүлэн СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-ийн дагуу бодит үнэ цэнээр хэмжин тайлагнадаг бодлоготой. Хавсаргасан санхүүгийн тайланд тусгагдсан охин компанид оруулсан хөрөнгө оруулалтууд нь 2014 оны 12 сарын 31–нээрх (2015 онд аливаа үнэ цэнийн материаллаг өөрчлөлт байхгүй гэж үзсэн) компанийн удирдлагын тодорхойлсон бодит үнэ цэнээр хэмжигдсэн. Компанийн удирдлага эдгээр охин компани тус бүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хараат бус үнэлгээчний ажлыг ашиглаагүй байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

БДО Аудит ХК

Улаанбаатар хот, Монгол Улс

Тусгай зөвшөөрөл: 009-1997

Огноо: 2016.6.7

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2015 мян.төг	2014 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны орлого	12,695,786	7,324,773
Үйлчилгээний өртөг	(1,740,211)	(1,122,042)
	-	-
Нийт ашиг	10,955,575	6,202,732
ХО-н бодит үнэ цэнийн хэрэгжилт	(9,944,563)	(6,545,956)
Цалин хөлс, түүнтэй адилтгах зардал	(245,996)	(390,231)
Ерөнхий удирдлагын зардал	(880,138)	(983,158)
	-	-
Үйл ажиллагаанаас олсон ашиг, алдагдал	(115,123)	(1,716,614)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ		
цэнийн үнэлгээний олз, гарз	-	(91,483)
Үйл ажиллагааны бус орлого	131,076	-
ХОЗҮХХ-ийн үнэ цэнийн өсөлт	-	415,583
Цэвэр санхүүгийн зардал	222,394	177,365
Бусад олз гарз	(10,000)	-
	-	-
Татварын өмнөх ашиг	228,347	(1,215,148)
Орлогын албан татварын зардал	(53,575)	(431,996)
Хойшлогдсон татварын орлого/(зардал)	-	1,186,489
	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	174,772	(460,656)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	933,684
Нийт дэлгэрэнгүй орлого	174,772	473,029
Жигнэсэн дундаж хувьцаа-ширхэгээр	16,423,567	15,237,113
Нэгж хувьцаанд ногдох ашиг -төгрөгөөр	10.64	(30.23)

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2015 оны 12 сарын 31 мян.төг	2014 оны 12 сарын 31 мян.төг	2013 оны 12 сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж	862,457	659,787	348,472
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	675,148	675,148	-
Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө	20,779,327	32,024,057	31,499,653
Нийт эргэлтийн бус хөрөнгө	22,316,933	33,358,993	31,848,126
Эргэлтийн хөрөнгө			
Урьдчилгаа	127,526	100,876	306,738
Бараа материал	20,150	1,301	16
Зээлийн авлага	1,824,681	729,145	1,122,148
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	177,820	0
Худалдааны ба бусад авлага	15,142,289	168,543	116,010
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,328,120	408,470	182,868
Нийт эргэлтийн хөрөнгө	18,442,765	1,586,155	1,727,780
НИЙТ ХӨРӨНГӨ	40,759,698	34,945,148	33,575,906
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал (Энгийн хувьцаа)	1,879,653	1,833,551	1,703,147
Халаасны хувьцаа	(160,216)	(154,018)	(326,929)
Халаасны хувьцаа -НТК	(512,084)	-	-
Нэмж төлөгдсөн капитал	10,441,144	9,298,760	3,246,555
Хуримтлагдсан ашиг	16,895,205	16,720,432	17,589,290
Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц	6,225,670	6,225,670	5,291,986
Өмчийн бусад хэрэглүүр	13,799	13,799	13,799
Нийт өмч	34,783,171	33,938,194	27,517,848
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	-	-	210,999
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	-	-	199
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	-	1,186,489
Нийт урт хугацаат зээл	-	-	1,397,687
Эргэлтийн өр төлбөр			
Худалдааны ба бусад өр төлбөр	5,844,769	267,853	2,449,893
Орлогын албан татварын өглөг	131,759	391,922	7,452
Бусад эргэлтийн өр төлбөр	-	136,179	136,179
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	-	211,000	2,042,055
Урт хугацаат санхүүгийн түрээсийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	-	-	24,793
Нийт эргэлтийн өр төлбөр	5,976,528	1,006,954	4,660,371
Нийт өр төлбөр	5,976,528	1,006,954	6,058,058
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	40,759,698	34,945,148	33,575,906
	(0)	-	(0)

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мян.төг	Халаасны хувьцаа мян.төг	Халаасны хувьцааны -НТК	Нэмж төлөгдсөн капитал мян.төг
2013 оны 12 сарын 31-ээр	1,703,147	(326,929)	-	3,246,555
Алдааны залруулга				
Залруулагдсан үлдэгдэл	1,703,147	(326,929)	-	3,246,555
Хувьцаа халаасласан		(57,397)		(114,654)
Эргэлтэнд гаргасан хувьцаа	130,404	230,309		6,166,857
Тайлант жилийн ашиг				
2014 оны 12 сарын 31-ээр	1,833,551	(154,017)	-	9,298,759
Хувьцаа халаасласан		(36,577)	(512,084)	
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	46,102	30,379		1,142,385
Тайлант жилийн ашиг				
2015 оны 12 сарын 31-ээр	1,879,653	(160,215)	(512,084)	10,441,144

	Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Өмчийн бусад хэрэглүүр мян.төг	НИЙТ мян.төг
2013 оны 12 сарын 31-ээр	5,291,986	13,128,835	13,799	23,057,392
Алдааны залруулга		4,460,455		4,460,455
Залруулагдсан үлдэгдэл	5,291,986	17,589,290	13,799	27,517,848
Хувьцаа халаасласан		(408,202)		(580,253)
Эргэлтэнд гаргасан хувьцаа				6,527,571
Тайлант жилийн ашиг		(460,656)		(460,656)
	933,684			933,684
2014 оны 12 сарын 31-ээр	6,225,670	16,720,432	13,799	33,938,194
Хувьцаа халаасласан				(548,661)
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа				1,218,865
Тайлант жилийн ашиг		174,772		174,772
2015 оны 12 сарын 31-ээр	6,225,670	16,895,204	13,799	34,783,171

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2015 мян.төг	2014 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:		
Татварын өмнөх ашиг	228,347	(1,215,148)
Тохируулга:	-	-
Татварын зардал	-	-
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	123,773	40,125
Хүүгийн орлого	(41,103)	(98,193)
Хүүгийн зардал	-	52,756
Гадаад валютын ханшийн зөрүү	(2,320)	(92,413)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээ	-	(323,686)
Данснаас хассан хөрөнгө	10,000	-
Хөрөнгө оруулаллт худалдсан олз	(675,835)	1,017,873
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(357,138)	(618,687)
	-	-
Бараа материалын (өсөлт)/бууралт	(18,848)	(1,285)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны (өсөлт)/бууралт	(56,260)	(94,396)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт	(14,234,966)	417,840
Урьдчилж орсон орлогын өсөлт/(бууралт)	-	-
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)	13,358,706	(2,571,664)
	-	-
Үйл ажиллагаанаас олсон бэлэн мөнгө	(1,308,507)	(2,868,192)
Хүлээн авсан хүү	41,103	229,782
Төлсөн орлогын татвар	(291,000)	(47,527)
Төлсөн хүү	-	(52,756)
	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,558,404)	(2,738,693)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(374,930)	(650,965)
Худалдсан өмчийн хөрөнгө оруулалт	4,980,659	6,650,125
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	(150,000)
Төлөгдсөн өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	45,000	-
Худалдан авсан ТБҮЦ	-	(27,820)
Худалдсан ТБҮЦ	22,760	-
Худалдан авсан өмчийн хөрөнгө оруулалт	(144,661)	(713,000)
Олгосон зээл	(2,442,622)	(431,337)
Олгосон зээлийн эргэн төлөлт	602,848	314,377
Худалдсан өмч, барилга, тоног төхөөрөмж	-	39,960
	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:	2,689,054	5,031,340
САНХҮҮЖИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:	-	-
	-	-
Зээлийн эргэн төлөлт	(211,000)	(2,067,045)
	-	-
САНХҮҮЖИЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:	(211,000)	(2,067,045)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ бууралт	(919,650)	(225,602)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	408,470	182,868
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,328,120	408,470
Шалгах	(0)	0

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП			
Хаалттай Хувьцаат Компани			
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн			
НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН			
	Тэм	2015 он мян.төг	2014 он мян.төг
Борлуулалтын орлого - цэвэр	6	19,076,935	14,369,078
Борлуулалтын өртөг	7	(5,361,057)	(4,542,836)
Нийт ашиг		13,715,877	9,826,242
Цалин хөлс, түүнтэй адилтгах зардал	8	(1,879,609)	(2,109,558)
Ерөнхий удирдлагын зардал	9	(3,564,530)	(4,209,600)
Үйл ажиллагааны ашиг		8,271,739	3,507,084
Санхүүгийн орлого/(зардал)	10	1,864,344	1,658,600
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн олз	19	-	415,584
Хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	11	187,263	260,037
Бусад орлого/(зардал)	12	231,179	(194,178)
Бусад олз/(гарз)	13	(105,924)	(9,597)
Татвар төлөхийн өмнөх ашиг		10,448,600	5,637,530
Орлогын татварын зардал	14	(166,382)	(538,321)
Хэвийн үйл ажиллагаанаас олсон ашиг		10,282,218	5,099,208
Зогсоосон үйл ажиллагаанаас олсон ашиг	15	9,802	-
Тайлант жилийн цэвэр ашиг		10,292,020	5,099,208
Хяналтын бус хувь оролцооны зардал	16	(67,766)	(360,229)
Группийн цэвэр ашиг		10,224,254	4,738,979
Нэгж хувьцаанд ногдох ашиг, алдагдал - төгрөг	17	606	312

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП				
Хаалттай Хувьцаат Компани				
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн				
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН				
	Тэм	2015 оны 12 сарын 31 мян.төг	2014 оны 12 сарын 31 мян.төг	2014 оны 01 сарын 01 мян.төг
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн бус хөрөнгө				
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	18	2,738,772	1,145,438	387,075
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	19	675,148	675,148	-
Биет бус хөрөнгө - цэвэр	20	44,109	55,069	61,086
Гүүдвил	21	5,128,272	5,002,175	546,612
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	22	1,109,413	2,801,927	3,910,968
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	23	2,531,446	2,314,573	2,054,536
Нийт эргэлтийн бус хөрөнгө		12,227,161	11,994,330	6,960,277
Эргэлтийн хөрөнгө				
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	24	572,768	668,237	311,926
Бараа материал	25	31,996	36,148	16
Зээлийн авлага	26	4,292,245	2,865,429	1,122,148
Худалдааны болон бусад авлага	27	11,686,888	2,789,983	552,974
Богино хугацаат хөрөнгө оруулалт	28	146,872	62,799	5,956
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29	7,473,572	5,941,202	206,518
Нийт эргэлтийн хөрөнгө		24,204,342	12,363,799	2,199,537
НИЙТ ХӨРӨНГӨ		36,431,503	24,358,130	9,159,814
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР				
Өмч				
Хувьцаат капитал	30	1,879,653	1,833,551	1,703,147
Нэмж төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа	31	10,400,013	9,257,629	3,205,424
Халаасны хувьцаа	30	(522,791)	(156,887)	(329,798)
Нэмж төлөгдсөн капитал - Халаасны хувьцаа	31	(5,547,966)	-	-
Өмчийн бусад хэсэг	32	13,799	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг, алдагдал		14,426,821	4,202,566	(128,651)
Хяналтын бус хувь оролцоо	33	2,497,818	2,684,975	-
Нийт өмч		23,147,347	17,835,633	4,463,921

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП				
Хаалттай Хувьцаат Компани				
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн				
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН				
	Тэм	2015 оны 12 сарын 31 мян.төг	2014 оны 12 сарын 31 мян.төг	2014 оны 01 сарын 01 мян.төг
Өр төлбөр				
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	34	139,611	222,381	210,999
Бусад урт хугацаат өр төлбөр		1,134	1,134	136,179
Хойшлогдсон татварын өр	35	3,467	1,932	-
Урт хугацаат өр төлбөр		144,213	225,447	347,177
Богино хугацаат өр төлбөр				
Худалдааны болон бусад өглөг	36	7,635,026	1,162,215	2,237,458
Эрсдэлийн нөөц	37	1,370,658	1,578,372	-
Орлогын татварын өглөг		174,044	424,697	44,212
Санхүүгийн түрээсийн өр төлбөр		-	-	24,992
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	34	534,057	388,620	2,042,055
Богино хугацаат зээл	38	263,000	94,725	0
Урьдчилж орсон орлого	39	3,163,159	2,512,242	-
Бусад эргэлтийн өр төлбөр		-	136,179	-
Нийт богино хугацаат өр төлбөр		13,139,944	6,297,049	4,348,717
Нийт өр төлбөр		13,284,157	6,522,496	4,695,894
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		36,431,503	24,358,130	9,159,814

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП		
Хаалттай Хувьцаат Компани		
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн		
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
	2015 он мян.төг	2014 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	10,448,600	5,637,530
ТӨА-ийн тохируулга:		
Өмч барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	248,190	117,424
Биет бус хөрөнгийн хорогдуулга	11,060	11,066
БҮТЭЗ-ийн хорогдуулга	2,476	-
Хараат компанийн (ашиг)/алдагдлын ногдох хэсэг	(187,263)	(260,037)
Эрсдлийн нөөцийн зардал	69,400	-
Найдваргүй авлагын зардал	71,666	57,791
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз/(олз)	126,373	9,597
Бараа материал данснаас хассан гарз/(олз)	7,844	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн гарз/(олз)	-	(415,584)
Зогсоосон үйл ажиллагааны алдагдал/(ашиг)	9,802	-
Хөрөнгө оруулалт данснаас хассаны гарз/(олз)	10,000	-
Охин компанийн худалдан авалтын үеийн олз	(38,415)	-
Ногдол ашгийн орлого	(50,002)	(16,102)
Хүүгийн орлого	(2,032,460)	(1,805,134)
Хүүгийн зардал	369,540	295,482
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	9,066,812	3,632,033
Ажлын капиталын өөрчлөлт:		
Бусад эргэлтийн хөрөнгийн бууралт/(өсөлт)	(3,096)	-
Урьдчилж төлсөн зардал, тооцооны бууралт/(өсөлт)	95,469	(356,311)
Бараа материалын бууралт/(өсөлт)	(6,168)	(36,132)
Зээлийн авлагын бууралт/(өсөлт)	(1,493,121)	(1,743,281)
Худалдааны болон бусад авлагын бууралт/(өсөлт)	(8,947,601)	(2,149,540)
Худалдааны болон бусад өглөг өсөлт/(бууралт)	6,442,445	(1,235,930)
Эрсдэлийн нөөцийн өсөлт/(бууралт)	(207,714)	1,578,372
Урьдчилж орсон орлогын өсөлт/(бууралт)	650,916	2,512,242
Бусад эргэлтийн өр төлбөрийн өсөлт/(бууралт)	(136,179)	136,179
Үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ	5,461,764	2,337,632
Төлсөн орлогын татвар	(391,249)	(155,464)
Хүүгийн төлөлт	(339,174)	(269,839)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,731,341	1,912,330

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2015 он мян.төг	2014 он мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(2,341,871)	(1,184,621)
Худалдсан борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	1,740,211	1,109,042
Оруулсан хөрөнгө оруулалт	(132,966)	(56,844)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(126,098)	(4,455,563)
Худалдсан өмч, барилга, тоног төхөөрөмж	373,973	39,673
Худалдаж авсан биет бус хөрөнгө	(100)	(5,050)
Хүлээн авсан ногдол ашгийн орлого	50,002	16,102
Хүлээн авсан хүүгийн орлого	1,987,240	1,659,873
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,550,392	(2,877,389)
САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Эргэлтэд гаргасан хувьцаа	1,218,864	6,527,572
Худалдаж авсан халаасны хувьцаа	(5,944,249)	(580,253)
Хяналтын бус хувь оролцоо	(254,923)	2,324,745
Авсан зээл	715,653	494,725
Зээлийн төлөлт	(484,709)	(2,042,053)
Санхүүгийн түрээсийн өглөгийн төлөлт	-	(24,992)
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,749,364)	6,699,746
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,532,369	5,734,687
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,941,202	206,517
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,473,572	5,941,202

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫГ БАГТААСАН ГРУПП
Хаалттай Хувьцаат Компани
2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мян.төг	Энгийн хувьцааны НТК мян.төг	Халаасны хувьцаа мян.төг	Халаасны хувьцааны НТК мян.төг	Хуримтлагд сан ашиг мян.төг
2014 оны 01 сарын 01-ээр	1,703,147	3,205,424	(329,798)	-	(128,651)
Алдааны залруулга	-	-	-	-	441
Хувьцаа халаасласан	-	(114,654)	(57,397)	-	(408,202)
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	130,404	6,166,859	230,309	-	-
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-	-
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	4,738,979
2014 оны 12 сарын 31-ээр	1,833,551	9,257,629	(156,887)	-	4,202,566
Хувьцаа халаасласан	-	-	(396,283)	(5,547,966)	-
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	46,102	1,142,384	30,379	-	-
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	10,224,254
2015 оны 12 сарын 31-ээр	1,879,653	10,400,013	(522,791)	(5,547,966)	14,426,821

	Өмчийн бусад хэрэглүүр мян.төг	Группэд хамаарах өмчийн дүн мян.төг	Хяналтын бус хувь оролцоо мян.төг	Нийт өмч мян.төг
2014 оны 01 сарын 01-ээр	13,799	4,463,921	-	4,463,921
Алдааны залруулга	-	441	-	441
Хувьцаа халаасласан	-	(580,253)	-	(580,253)
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	-	6,527,572	-	6,527,572
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	2,324,745	2,324,745
Тайлант жилийн ашиг	-	4,738,979	360,229	5,099,208
2014 оны 12 сарын 31-ээр	13,799	15,150,659	2,684,975	17,835,634
Хувьцаа халаасласан	-	(5,944,249)	-	(5,944,249)
Эргэлтэнд гаргасан халаасны хувьцаа	-	1,218,864	-	1,218,864
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	(109,286)	(109,286)
Зарласан ногдол ашиг	-	-	(145,637)	(145,637)
Тайлант жилийн ашиг	-	10,224,254	67,766	10,292,020
2015 оны 12 сарын 31-ээр	13,799	20,649,529	2,497,818	23,147,346

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЗААВАР



1

Хэрэв та хувьцаа худалдан авах гэж байгаа бол заавал **Үнэт Цаасны Данстай** байх шаардлагатай. Хэрэв та **Үнэт Цаасны Дансгүй** бол “Ард Секюритиз ҮЦК” ХХК -д хандаж данс нээлгэх боломжтой.



2

“Хувьцаа худалдан авах саналын маягт” -ыг бөглөж шуудангаар Ард Санхүүгийн Нэгдэлийн албан ёсны хаягаар илгээнэ. Арын нүүрэнд байгаа саналын маягтыг ашиглана уу.



3

“Ард Секюритиз ҮЦК” ХХК -ийн харилцагч банкны дансанд **Хувьцааны төлбөр болон шимтгэлийг** шилжүүлнэ.

ДАНС :

Банк : Хас Банк
Данс : 5000232715
Хүлээн авагч : “Ард Секюритиз ҮЦК” ХХК



4

Хувьцаа худалдан авагч нь “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ” -нд гарын үсэг зурж нотариатаар баталгаажуулна.



5

“Ард Секюритиз ҮЦК” ХХК -ийн ажилтан холбогдох бичиг баримтыг “ҮЦТХТ” ТӨХХК -д бүртгүүлснээр Хувьцаа худалдан авагч нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК -ийн албан ёсны **Хувьцаа Эзэмшигч** болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ САНАЛЫН МАЯГТ

1	Огноо	
2	Хувьцаа эзэмшигчийн овог нэр / Байгууллага бол удирдлагын нэр	
3	Регистрийн дугаар / Улсын бүртгэлийн дугаар	
4	Хаяг Гэрийн хаяг	
5	И-мэйл хаяг	
6	Хувьцаа худалдах эсхүл худалдан авах эсэх Сонгож бичих	
7	Үнэт цаасны дансны дугаар Заавал бөглөхгүй байж болно.	
8	Хувьцаа худалдах эсхүл худалдан авах нэг бүрийн үнэ	
9	Худалдах эсхүл худалдан авах нийт хувьцааны тоо	
10	Холбоо барих утас	

Гарын үсэг: _____ / _____ /
Овог нэр.





"Ард Холдингс"-ын байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс



+(976) 7707 8080



+(976) 7707 8080



info@ardholdings.com



www.ardholdings.com